

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА,ТАМГЫН ГАЗРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ,  
ҮР ДҮНД ҮНЭЛГЭЭ ӨГСӨН ТАЙЛАН**

2010.03.25

Архангай аймгийн Засаг дарга нь Монгол Улсын Засгийн Газрын болон өөрийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх жилийн хүрээнд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэхэд ажлаа чиглүүлж ажиллалаа.

Аймгийн Засаг дарга, Тамгын Газрын 2009 оны үйл ажиллагаанд ХШҮ хийхдээ Засгийн Газрын 2010 оны 11 дугаар тогтоолоор баталсан “Яам болон аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үр дүнг үнэлэх журам”-ыг баримтлан хийсэн болно.

**Нэг. Бодлогын зорилтын хэрэгжилтын үр дүнгийн үнэлгээ**

**1. Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт**

Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт Архангай аймагт 2009 оны жилийн эцсийн байдлаар 30 хувийн биелэлттэй байна /Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийг хавсаргав/.

**2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт**

Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2009 оны биелэлтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийхдээ аймгийн Засаг дарга нар шууд хариуцан хэрэгжүүлэх 79 зорилт, 130 арга хэмжээг хяналтанд авч , аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнүүдэд тусган уялдуулан ажилласан.

Тус хөтөлбөрийн хэрэгжилтэнд 2009 оны жилийн эцсээр ХШҮ хийхэд 59.0 хувьтай байна. / хөтөлбөрийн хэрэгжилтийг хавсаргав./

**3. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт**

Архангай аймгийн хэмжээнд нийтдээ Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор батлагдсан 85 үндэсний хөтөлбөр хэрэгжиж байна. Үүнд:Хөдөө аж ахуйн салбарт-17, Байгаль орчны салбарт-24, Боловсрол соёлын салбарт-11, Нийгмийн халамжийн салбарт-7, Хууль зүйн салбарт- 9 , Эрүүл мэндийн салбарт-13, Санхүү, үйлдвэрлэлийн салбарт- 3 хөтөлбөр хэрэгжиж байна.

Малын эрүүл мэнд, Англи хэл, Бичиг үсгийн үндэсний хөтөлбөр /17/, Зайны сургалт, Сургуулийн өмнөх боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр /15/, Ногоон хувьсгал, Монгол бичиг, Малын чанар сайжруулах

үндэсний хөтөлбөр /14/, Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөр/13/, Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл үндэсний хөтөлбөр/12/, Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах ; “Сүү” үндэсний хөтөлбөр/11/, Морин хуур, уртын дуу; Хөдөөгийн айл, өрхийн цахилгааны эх үүсвэр, мэдээллийн хэрэгслийн хангалтыг сайжруулах; Усны тухай үндэсний хөтөлбөр; “Атрын 3 дахь аян”/10/ зэрэг үндэсний хөтөлбөрүүд аймгийн хэмжээнд 10-17 суманд хэрэгжиж жигд сайн буюу зарим тодорхой үр дүн гарч эхэлж байна.

Монгол хөөмий, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих, Биологийн төрөл зүйлийг хамгаалах, Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай, Агнуурын загасыг хамгаалах, өсгөн үржүүлэх, Сохорлоос сэргийлэх, тэмцэх, Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг үндэсний хөтөлбөр зөвхөн нэг суманд л хэрэгжиж байгаа нь харьцангуй хангалтгүй гэж үзэж болохоор байна.

Нийт салбарын үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хувиар авч үзвэл 16 хөтөлбөр - 70-80%, 21 хөтөлбөр - 60-70%, 46 хөтөлбөр - 40-60%- тай байна

Зарим үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт удааширч, саатсан , хэрэгжихгүй байгаа нь хөрөнгө санхүүгийн эх үүсвэр байхгүй, үйл ажиллагааны зохион байгуулалт, санал, санаачилга дутаж байгаатай холбоотой юм.

Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт Архангай аймагт 2009 оны байдлаар 70.9 хувийн биелэлттэй байна /Хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийг хавсаргав/.

## **Хоёр. Бодлогын зорилтын хэрэгжилтын зохицуулалтын үнэлгээ**

### ***1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт***

Аймгийн эдийн засаг, санхүү, төсвийн тогтвортой тэнцвэрт байдлыг хангах замаар улс, орон нутгийн төсвийн байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн жигд явуулахад санхүү, эдийн засгийн хүндрэлийн үр дагаварыг сайтар тооцон төсвийн орлого, зарлагын тэнцвэрт байдлыг ханган эх үүсвэртэй нь уялдуулан тооцож жигд явуулах боломжийг бүрдүүлэн төсвийн байгууллагын үйл ажиллагааг бага зардлаар хэвийн явуулж, төсөв хэмнэх зорилгоор зарим урсгал зардлыг бууруулж тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааг алдагдуулахгүй байхаар зохион байгуулан ажиллаж ирлээ.

Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийг хэрэгжүүлж төсвийн зарлагыг эдийн засгийн бодит хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чиглүүлэх, зарлагын менежментийг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгон, төсвийн ил тод байдлыг хангахад чиглүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт 83.7 хувьтай гарсан /Биелэлтийг хавсаргав/

## **2. Хууль тогтоомж, Засгийн Газрын шийдвэрийн хэрэгжилт**

2009 онд аймгийн хэмжээнд Засгийн Газрын 186 тогтоол, 58 хуралдааны тэмдэглэлийн нийт 337 заалтыг хяналтанд авч хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлт 85,4 хувийн үр дүнтэй гарсан.

Эдгээрээс үйл ажиллагаа нь бүрэн хэрэгжиж тогтворжсон 33 тогтоолын 46 заалтыг хяналтнаас хассан.

Засгийн Газрын шийдэрүүдийг хэрэгжүүлж ажиллах талаар агентлаг, сумдын удирдлагуудад 1-2 удаа зөвлөмж чиглэл хүргүүлэн, шаардлагатай тогтоол, шийдвэрийг хүргүүлэн ажилласан.

2009 оны 1 сард агентлагуудын дарга нарт болон сумдын Тамгын газрын дарга нарын семинарын үеэр тогтоол шийдвэрийн биелэлтийн дүнг танилцуулж, алдаа дутагдлыг нь сум, байгууллага тус бүр дээр ярьж ойлгуулан, цаашид анхаарах асуудлуудыг хэлж, зөвлөмж өгч, 22 тогтоолын 33 заалтыг шинэчлэн баяжилт хийж бүх сум, байгууллагуудад хүргүүлсэн.

2009 онд 21 агентлаг, 19 сумаас Засгийн газрын 115 тогтоолын 134 заалт, 34 хуралдааны тэмдэглэлийн 42 заалт, 5 албан даалгаврын 15 заалтын биелэлтийг гаргуулж хэрэгжилтийг тооцож ажилласан.

Засгийн Газрын тогтоол шийдвэрийн биелэлт Ихтамир, Тариат, Өндөр-Улаан, Цэцэрлэг, Хайрхан, Хашаат, Эрдэнэбулган сумд Зааврын дагуу сайн зохион байгуулж гаргаж ирүүлсэн. Дээрхи сумдад 80-90 хувийн биелэлттэй, үлдсэн сумдад 60-70 хувийн хэрэгжилттэй байна .

Сумын түвшинд Засгийн Газрын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх талаар зарим нэг онцлох сайшаалтай ажлууд хийгдсэн байна. Тухайлбал :

Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Өндөр –Улаан сумын Азарга багийн Улаан булан, багийн Засаг даргын болон хүний бага эмчийн үзлэг хийх өрөөг улсын төсвийн хөрөнгөөр тохижилт хийх ажлыг гүйцэтгүүлж, жишиг баг болгох ажлыг бүрэн хийж шийдвэрлэсэн байна. Эрдэнэмандал, Хашаат сумдууд дээрхи хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар тодорхой ажлууд хийсэн байна.

Эрдэнэмандал сум 3 багийн төвийг шинээр барьсан. Багуудын Засаг дарга нарыг мотоцикльтой болгосон ба 2 багийн хүний эмч мотоцикльтой болсон . Баг бүр “Ямаха“ хөгжим, Ямаха мотор цахилгаан үүсгүүрээр хангагдсны дээр ХЯБХ-ийн хүрээнд ширээ сандал, сейфээр 2 баг хангагдав. Багийн албад багийн төв дээр суурьшсан нь төрийн үйлчилгээг ард иргэдэд чирэгдэлгүй хөнгөн шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэн ажилласан байна.

Хашаат сумын Номгон, Цагаанхад багийн Засаг дарга нар өөрсдийн санаачлагаар багийн төвийг тохижуулсан. Цайдам, Цагаанхад багт Инкомнит суурин телефон тавигдсан байна.

Цэнхэр сумын Орхон , Цэнхэр, Цэцэрлэг, Буйлан багуудад ТА-2 төслийн хүрээнд мал аж ахуй, булгийн эх хаших чиглэлээр 11сая 660 мянган төгрөгийн ажил хийж 150 иргэнийг түр ажлын байраар ханган ажилласан байна.

Нийт агентлаг, сумдад Засгийн газрын Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай. 1999 оны 55 дугаар, Ган, зуд, ус, цаг агаарын аюулаас урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2000 оны 190 дугаар тогтоол, Сумын хөгжлийн сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2001 оны 157, Цэвэр орчин аян зохион байгуулах тухай 2001 оны 205, Өрх хүн амын орлого, зарлагын мэдээллийн талаар авах зарим арга хэмжээний тухай, Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдэд нэг цэгийн үйлчилгээгээр үйлчилгээ үзүүлэх тухай 2002 оны 35, Нэг сум- нэг бүтээгдэхүүн хөтөлбөр батлах тухай 2005 оны 138, Эрүүл монгол хүн үндэсний хөтөлбөр батлах тухай 2006 оны 91, Цөм сүргийн үржлийн төв байгуулах тухай 2006 оны 172 дугаар, Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг бууруулах тухай 2009 оны 356 дугаар тогтоолууд амжилттай хэрэгжиж үйл ажиллагаа нь тогтворжсон байна.

Мөн өргөдөл, гомдол шийдвэрлэх тухай Засгийн Газрын 2005 оны 67 дугаар тогтоол , Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах тухай Засгийн Газрын 2007 оны 190 дугаар тогтоолын биелэлтийг хэрэгжүүлж ажиллах тал дээр Эрдэнэбулган, Эрдэнэмандал, Цэнхэр, Хайрхан сумд тодорхой ажил зохион байгуулан сайн ажилласан байна.

Засгийн Газрын 2007 оны 63, Адууны томуу өвчний цагийн байдлын тухай, Цагаан сарын баяр тэмдэглэн өнгөрүүлэх тухай, 2009 оны 9 дугаар, цаг агаарын аюултай үзэгдлийн тухай сэрэмжлүүлэг мэдээг малчид, ард иргэдэд шуурхай хүргэж, гамшигаас урьдчилан сэргийлэх тухай 2009 оны 41 дугаар, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай 2009 оны 56 дугаар, 2009 оны төсөвтөө багтан үйл ажиллагаагаа явуулж, шинэ жилийн баяр ёслолын үйл ажиллагаанд хавтгайруулан зардал гаргахгүй байх тухай, 2009 оны 68 дугаар Томуугийн А хүрээний /H1N1/ вирусын өвчлөлд жирэмсэн эхчүүдэд хууль ёсны амралтын нь өмнө нэг сарын цалинтай чөлөө олгох арга хэмжээ авах тухай зэрэг Засгийн Газрын хуралдаанаар өгсөн үүрэг, даалгаварууд цаг тухайдаа шуурхай хэрэгжсэн болно. Сум, байгууллагын Засгийн Газрын шийдвэрийн биелэлтэнд ХШҮ хийхэд 75,8 хувьтай гарсан.

ОБХ, БТСХэлтэс, БСГ, ЭМГ, ХТТ, Татварын хэлтэс , ХХҮХ, Статистикийн хэлтэс зэрэг газрууд дээр тогтоол шийдвэрийн биелэлт 80 –аас дээш хувьтай хэрэгжиж байна.

Харин ХХААЖДҮГ, БОГазар дээр зарим тогтоолын хэрэгжилт 70- 65 хувийн хэрэгжилттэй байна.

### ***3. Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт***

***За. Монгол улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар:***

Тус аймаг Монгол улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон төрийн байгууллагуудын жилийн ажлын төлөвлөгөөнд холбогдох заалтыг харъяаллын дагуу тусган гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 130 заалтыг хяналтанд авч биелэлтийг тооцон үзэхэд өнгөрсөн жилийн гүйцэтгэл 59,0 хувьтай байна. Хөтөлбөрт тусгасан арга хэмжээ бүрийн гүйцэтгэлийн биелэлтийг хавсралтаар дэлгэрэнгүй гаргасан.

### ***36. Монгол улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх***

Аймгийн Засаг дарга бүрэн эрхийнхээ дагуу нутаг дэвсгэрийн хүрээнд дагаж мөрдөх ажлын зохион байгуулалт шийдвэрлэлийн 446 захирамжийг Монгол улсын хууль тогтоомжод нийцүүлэн гаргасан. Уг шийдвэрүүд нь хууль эрхийн үндэслэлийг хангасан тул ХЗДХЯ болон Ерөнхий сайдын зүгээс өөрчлөх, хүчингүй болгох тохиолдол гараагүй болно. Аймгийн ЗДТГ-ын хууль тогтоомжийн бүртгэл лавлагааны санд 2531 эрх зүйн акт байгаа бөгөөд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 540 төрлийн хууль эрхийн мэдээлэл, лавлагаа өгч үйлчилсэн.

### ***37. Хүнд суртал чирэгдлээс ангижрах***

Төрийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг хөнгөн шуурхай болгох, ард иргэдэд чирэгдэлгүй үйлчлүүлэх үүднээс Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Хүний эрхийн судалгааны төвтэй хамтран “Нэг цонх-ны үйлчилгээг 2009 оны 7 дугаар сараас нээн ажиллуулж байна.”Нэг цонх “-ны үйлчилгээний байрыг засварлаж тохижуулахад орон нутгийн төсвөөс 7.0 сая төгрөг зарцуулав.

Энэхүү “Нэг цонх” -оор өдөрт дунджаар 80 иргэнд нийгмийн халамж, иргэний бүртгэл мэдээлэл, нийгмийн даатгал, газрын харилцааны чиглэлээр төрийн үйлчилгээг хүргэж банк, нотариат зэрэг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж иргэдэд үйлчилж байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх, хүнд суртал чирэгдлийг арилгах чиглэлээр үйл ажиллагаа явуулах орон нутаг дахь төрийн бус байгууллагын сүлжээтэй хамтран ажиллах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын Газрын Хууль зүйн хэлтсийн эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусган хариуцуулав.

Аймаг, сумдын Засаг даргын Тамгын Газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагийн төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт болон үр дүнгийн гэрээнд төрийн албан хаагчийн ёс зүйг чанд сахиж ажиллахыг тусгайд нь нэг заалт болгон оруулж 2009 оны гэрээ дүгнэхдээ харгалзан тооцов.

Төрийн албаны тухай хууль, дотоод журам зөрчсөн, ажлын сахилга бат алдаж хариуцлага сулруулсан, үүрэг даалгавар биелүүлээгүй ажилтнуудтай хууль тогтоомжоор олгогдсон эрх хэмжээний хүрээнд шат шатандаа хариуцлага тооцож

байна. 2009 онд аймгийн Засаг даргын захирамжаар 4, сумдын Засаг дарга нарын захирамжаар 30 гаруй, аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар 3, сумдын Засаг даргын Тамгын Газрын даргын тушаалаар 16 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулан хариуцлага тооцсон.

Аймаг, сумдын Засаг даргын Тамгын Газар, агентлаг, хууль хяналтын болон төрийн үйлчилгээний байгууллагууд өөрийн үйл ажиллагааны чиг үүрэг, иргэдэд үзүүлэх үйлчилгээ, журам, заавар, бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт, болон хийж буй ажлынхаа явцын талаар мэдээллийн самбарт тавьж иргэдийг мэдээлэл авах боломжоор ханган, үйлчлүүлэгчиддээ тайлангаа тавьж хэлэлцүүлэн, “Нээлттэй хаалганы өдөр” зохиож иргэдийн санал бодлыг сонсож түүний мөрөөр ажил зохиож хариу мэдээлэх зэргээр төр иргэдийн холбоо, харилцан итгэлцлийг бэхжүүлэх нээлттэй байдлыг хангахад чиглэсэн олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажлыг хуулийн дагуу тендер зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажлын үр дүнг иргэдэд мэдээлж байна. 2009 онд улсын төсвийн хөрөнгөөр 14 объектод тендер зарлан 1,9 тэрбум төгрөгийн, зээл тусламжийн хөрөнгөөр 4 объектод 149,3 сая төгрөгийн барилга угсралтын болон барилга засвар, тэжээлийн агуулах, халуун ус барих, худаг гаргах ажлууд хийгдэв.

Төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбогдуулан аймгийн Аудитын газар улсын болон орон нутгийн төсвийн 66 байгууллагын 2008 оны санхүүгийн тайланд аудит хийж төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой 17,1 сая, бүртгэл тайлантай холбоотой 320,1 сая төгрөгийн зөрчил илэрснийг аудитын явцад залруулсан. 2009 онд төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаар мэдээлэл “Архангайн амьдрал” сонинд 4 удаа нийтлэгдсэн. Аймгийн ИТХ-ын 5-р хуралдаанаар хэлэлцсэн аймгийн Аудитын газрын тайланд орон нутгийн төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт зарцуулалтын байдалд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчил, дутагдлууд тодорхой тусгагдаж нийтэд мэдээлэгдсэн.

Аймгийн ИТХТ-ийн тогтоолоор “Төсвийн хөрөнгийн зарцуулалт, түүний үр ашгийн байдалд шалгалт хийх ажлын хэсэг” байгуулж Өндөр-Улаан, Цэцэрлэг, Цэнхэр сумдын Засаг даргын Тамгын Газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сургууль, цэцэрлэг, хүн эмнэлэг, аймгийн Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёлын газруудад шалгалт хийлгүүлэв. Аймгийн ИТХТ-ийн хуралдаанаар “Орон нутгийн төсвийн нөөцийн болон замын сан, хөрөнгө оруулалтын сангийн хуваарилалтын байдал” орон нутгийн болон улсын төсвийн байгууллагуудын 2008 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн”-г хэлэлцэн цаашид ажиллах ажлын чиглэл гаргаж мөрдүүлэв.

Шийдвэр гаргах түвшинд иргэд, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ИТХТ-ийн шийдвэрээр аймгийн ИТХ-ын дэргэд “Иргэдтэй харилцах танхим” нээн ажиллуулж байна.

***Зг. Аймгийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг сайжруулж, төсвийн сахилгыг сахих***

Архангай аймаг 2009 онд орон нутгийн төсвийн орлогоор 2760,7 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 2838,5 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 102,8 хувиар биелүүллээ.

Орлогын зүйлчлэлээр авч үзэхэд цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар 280,2 сая, орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгч иргэний татвар 7,5 сая, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 11,0 сая, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар 11,8 сая, ойгоос түлээ мод бэлтгэж ашигласны төлбөр 33,2 сая, төсөвт байгууллагын өөрийн орлого 23,6 сая, хүү торгуулийн орлого 50,6 сая төгрөгөөр тус тус давж биеллээ.

Харин ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 295,6 төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 21,1 сая төгрөгөөр, ус ашигласны төлбөр 36,3 сая төгрөгөөр тасарсан. Төсвийн зарлагын гүйцэтгэл 3791,8 сая төгрөг буюу 97,9 хувьтай байна. Төсвийн гүйцэтгэлийг нийт зардалд эзлэх төсвийн зардлын хувийн жингээр авч үзвэл 59,2 хувийг цалин шимтгэлд, 4,1 хувийг мал эмнэлгийн үйлчилгээний хөлсөнд, 3,9 хувийг тэтгэмж урамшуулалд, 1,1 хувийг замын санд, 31,7 хувийг бусад бараа үйлчилгээний зардалд зарцуулсан байна.

Улсын төсвийн урсгал санхүүжилтээр 17922,6 сая, төсөвт байгууллагуудын өөрийн орлогоор 235,8 сая, тусламжийн орлогоор 61,2 сая нийт 19338,3 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, 19238,5 сая төгрөг зарцууллаа.

Тус аймагт 1,072,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал батлагдсанаас гүйцэтгэлээр 1032,9 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж 39,5 сая төгрөг сангийн яаманд буцаан төвлөрсөн. Хөрөнгө оруулалтаар шинээр буюу засвар хийгдсэн 12 объектийг улсын болон техникийн комисс хүлээн авч ашиглалтанд өгсөн.

### ***3д. Эдийн засаг нийгмийн бодит өсөлтийг хангаж, соёл, боловсрол, эрүүл мэндийн хөгжлийг хангах***

Тайлант хугацаанд нийгмийн хамгааллын салбарын үйл ажиллагаа хэвийн явагдаж тавьсан зорилтоо хэрэгжүүлж ажиллаа. 2009-2010 оны хичээлийн жилд цэцэрлэгийн насны хүүхдийн 45 хувь нь цэцэрлэгт хамрагдаж СӨБ-ын бусад хэлбэрийн хувилбарт сургалтанд 30 хувь нь буюу нийт хүүхдийн 75 % нь сургуулийн өмнөх боловсролын сургалтанд хамрагдлаа. Мөн хичээлийн жилд 9-с дээш насны 611 суралцагч дүйцсэн хөтөлбөрт хамрагдан суралцаж байна. Сургууль соёлын байгууллагын орчныг сайжруулах үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн томоохон хөрөнгө оруулалтыг хийж Тариат, Өлзийт сумын хичээлийн байр, Цэцэрлэг, Эрдэнэбулган сумын хүүхдийн цэцэрлэг, Өгийнуур сумын спорт заал, Цэнхэр сумын дотуур байр, Цахир сумын соёлын төвийн барилгуудыг шинээр барих болон их засварын ажил гүйцэтгэлээ.

Эрүүл мэндийн үйлчилгээг чанаржуулах, эмнэлгийн байгууллагыг бэхжүүлэн аймгийн төвд хүүхдийн төрөлжсөн эмнэлэг, халдвартын эмнэлгийг шинээр барьж ашиглалтанд оруулан эмчилгээ оношлогооны шаардагдах багаж тоног төхөөрөмжөөр хангах ажлууд хийж тодорхой үр дүнд хүрээд байна. Тухайлбал 0-15 насны хүүхдийн эндэгдэл 8, 0-1 насны хүүхдийн эндэгдэл 5-р буурч 1000 амьд төрөлтөнд 23,1

промилль хүрч өнгөрсөн оныхоос 4 промилээр буурлаа.Өнгөрсөн онд 1553 эх төрсөн нь өмнөх оныхоос 45-р нэмэгдэж,амьгүй төрөлт 3 тохиолдлоор буурсан.

Иргэдийн нийгмийн хамгааллын хүртээмжийг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах талаар төсвийн болон төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтыг чиглүүлж ажилласан. Сум тус бүрт амьжиргааны түвшинг ахиулж ядуурлаас гаргах өрхийн тоог тогтоон өгч тэднийг орлого олох нийтийг хамрасан ажилд хамруулах, мэргэжил олгох сургалтанд суулгах, зээл тусламжинд хамруулах арга хэмжээ авснаар 232 өрхийн амьжиргаанд ахиц гарлаа. Ажилгүй мэргэжилгүй 497 иргэн, залуучуудад барилгын засварчин, гагнуурчин, сантехникч, талх нарийн боовчин, оёдолчин зэрэг мэргэжлээр сургалт зохион байгуулж 52,2 сая төгрөг зарцууллаа.

Өнгөрсөн онд 1614 ажлын байр шинээр бий болгосон нь өмнөх оныхоос 311-р нэмэгдсэн.

### ***Зө. Нийгмийн дэг журмыг хангаж, гэмт хэрэг ,архидан согтуурахтай тэмцэх***

Иргэдийн хууль эрхийн мэдлэгийг дээшлүүлж гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сурталчилгааны материал боловсруулан 3310 хүнийг хамруулан яриа таниулга хийж 2870 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмж тараасан.

Аймгийн хэмжээнд 2009 онд 431 гэмт хэрэг бүртгэгдсэний 132 нь хүний амь бие,эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 217 нь өмчлөх эрхийн эсрэг хэрэг гарчээ. Нийт хэргийн гаралт өмнөх оныхоос 95-р буурсан. Цагдаагийн байгууллагын ажиллах нөхцөлийг сайжруулах, орон нутагт цагдаагийн кабон байгуулах, иргэдэд гэмт хэрэг ,зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй хийж буйн үр дүн гарч байна.Гэмт хэрэгт оролцогчдын тоо өмнөх оныхоос 69 хүнээр, эрүүлжүүлэгдсэн хүний тоо 176, гэмт хэргийн улмаас бэртэж гэмтсэн хүний тоо 53 тохиолдлоор тус тус буурлаа.

Архи согтууруулах ундааны хууль бус худалдааг зогсоох, архидан согтуурахтай хийх тэмцлийг хууль журмын дагуу зохион байгуулж байна. Аймгийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн байгууллагын хамтарсан үзлэг шалгалтыг бүх сум, худалдаа эрхлэгч байгууллагыг хамруулан зохион байгуулсан.Шалгалтын явцад зөрчилтэй байсан 40 гаруй цэгийн согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болголоо. Хэрэг үйлдэхдээ согтуу байсан иргэдийн тоо өмнөх оныхоос 59 тохиолдлоор буурсан.

### ***Зё. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт***

2009 онд аймгийн хэмжээнд Засгийн газрын 186 тогтоол, 58 хуралдааны тэмдэглэлийн нийт 337 заалтыг хяналтанд авч хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлт 85,4 хувийн үр дүнтэй гарсан /Батламжийн биелэлт 95.0 хувьтай гарсан.

#### **4.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт**

Аймгийн Засаг дарга миний бие өөрийн бүрэн эрхийн хугацааны үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхдээ Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан аймаг, орон нутгийн онцлог, тулгамдсан асуудлыг харгалзан нийт 138 зорилт, 536 ажил арга хэмжээг тусгасан төлөвлөгөөг боловсруулж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн батлуулаад мөрдөж ажиллалаа.

2009 оны жилийн эцсийн байдлаар аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 70.0 хувьтай гарсан /Хөтөлбөрийн хэрэгжилтийг хавсаргав/. Аймгийн Засаг даргын хөтөлбөрт тусгагдсан асуудлуудаас амжилттай хэрэгжиж байгаа ажлуудыг товч дурдвал:

**Эрүүл мэндийн салбарын хүрээнд 2009 онд** манай эрүүл мэндийн салбарт сүүлийн 10 жилд хийгдээгүй томоохон хөрөнгө оруулалтын асуудлууд шийдэгдэж бусад дэмжлэг, хамтын ажиллагааны эхлэл тавигдлаа.

Эмнэлгийн материаллаг баазыг бэхжүүлэх, хэвтэн эмчлүүлэгчдийн үйлчилгээний ээлтэй байдлыг хангах зорилгоор аймгийн Нэгдсэн эмнэлэгт улсын төсөв болон төсөл хөтөлбөрийн хүрээнд нийт 52 нэр төрлийн 106.3 сая төгрөгийн багаж, тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл,Цэцэрлэг, Батцэнгэл, Өлзийт, Цахир сумдын эмнэлгүүдийг зайлшгүй шаардлагатай 8 нэр төрлийн 43.0 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмжөөр хангаж Нэгдсэн эмнэлэгт яаралтай түргэн тусламжийн 56.2 сая төгрөгийн өртөг бүхий 2 автомашин олгосон байна.

Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 0-15 насны хүүхдийн эндэгдэл 7, 0-1 насны хүүхдийн эндэгдэл 5 тохиолдлоор тус тус буурч 1000 амьд төрөлтөнд 24.0 промилль байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 3.1 промилоор буурсан байна.

Халдварт өвчин өмнөх оны мөн үеийнхээс 197 тохиолдлоор буурсан нь 10000 хүн амд өвчний тохиолдол 57.7 болж улс ,аймгуудын дунджаас доогуур үзүүлэлттэй байна

**Боловсролын салбарын хүрээнд** ерөнхий боловсролын сургуулийн 676 бүлэгт 20164 хүүхэд суралцаж, хүүхдийн цэцэрлэгт цэцэрлэгийн насны нийт хүүхдийн 45.8 хувь буюу 2931 хүүхэд, сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтанд 29.2 хувь буюу 1756 хүүхэд хамрагдаж сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 75.0 хувьд хүрлээ.

Цэнхэр сумын сургуулийн дотуур байранд 160.0 сая төгрөгийн, Өлзийт сумын хичээлийн байранд 98.6 сая төгрөгийн, Хашаат сумын сургуулийн хичээлийн байранд 130.0 сая төгрөгийн, Цэцэрлэг сумын сургуулийн хичээлийн байранд 50,0 сая төгрөгийн, Хангай сумын сургуулийн дотуур байрны барилгад 40 сая төгрөгийн, Эрдэнэбулган сумын хүүхдийн 6 дугаар цэцэрлэгт 20.0 сая төгрөгийн, Хотонт сумын Өндөр сантын соёлын төвийн барилгад 39.9 сая, газар хөдлөлтийг бүртгэх “Цэцэрлэг” станцын барилгад 25.4 сая төгрөгийн их засварын ажил тус тус хийгдсэн

байна.Багшийн коллежийн 960 хүүхдийн суудалтай хичээлийн байр баригдаж эхлээд байна.

Эрдэнэбулган сумын 4-р сургууль, Ирээдүй цогцолбор, Боловсрол соёлын газар, Батцэнгэл, Өгийнуур сумын сургуулийг шилэн кабелиар интернэтэд, Тариат, Цэнхэр, Ихтамир сумдын сургуулийг VISAT-аар интернэтэд холбосон байна. Энэ онд англи хэлний 31 багш ваакумжуулсан, ерөнхий боловсролын сургуулийн 40 багш зайн сургалтанд хамрагдаж Багшийн коллеж, Эрдэнэбулган сумын “Хүмүүн ” цогцолборын 1,2, 3-р сургуулиудад англи хэлний иж бүрэн онлайн кабинет байгуулагдлаа.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн өдрийн ангид 1357 оюутныг элсүүлэн, 408 оюутныг 1- 2.5 жилийн сургалтаар төгсгөснөөс 66.4 хувь нь ажлын байртай болсон буюу их , дээд сургуульд дэвшин суралцсан байна.

Аймгийн нийтийн номын сан болон сум, сургуулиудын номын сангийн фондыг 109.5 сая төгрөгийн 11365 ширхэг номоор баяжуулсан байна.

Музейн зарим үзмэрийг сэргээн засварлаж олон жил фондод хадгалагдаж байсан үзмэрийг үзмэрийн танхимд шилжүүлэн шинэчлэн зохион байгуулж аймгийн төвд 4 удаа, Баянхонгор, Өвөрхангай зэрэг аймгуудад нүүдлийн үзэсгэлэн гаргаж 10000 гаруй иргэд, гадаадын жуулчдад түүх соёлын үнэт болон дурсгалт зүйлийг сурталчилсан байна.

**Нийгмийн хамгааллын хүрээнд** хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрт орон нутгийн төсвөөс 2.5 сая төгрөг, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас хэрэгжүүлж байгаа хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 7 төсөлд 19.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж 35 хүн үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж ажлын байраар хангагд-сан байна.Мөн “Нийгмийн халамжийн сан”-гаас олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлж 31.6 сая төгрөгийн, иргэний нийгмийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх зорилгоор 35.4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

“Хүнс тэжээл, нийгмийн халамжийн хөтөлбөр”-т 1742 иргэнийг хамруулахаар сумдын “Амьжиргааг дэмжих зөвлөл”-өөр хэлэлцүүлэн баталж 11 сараас эхлэн хүнсний бүтээгдэхүүнийг иргэдэд олгож эхлээд байна.

Энэ онд нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 1062 иргэн хамрагдсан бөгөөд түүний 60 гаруй хувь нь малчид байна.

“Нийгмийн халамжийн сан”-гаас 56087 хүнд 7186.1 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээ үзүүлснийг нийт хүн амын тоотой харьцуулбал 62,8 хувь нь төрийн үйлчилгээнд хамрагдаад байна.

**Эдийн засаг, санхүүгийн салбарт** Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 102,8 хувиар биелж, 77,8 сая төгрөгөөр давсан байна. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр нь авч үзвэл: Хувь хүний орлогын албан татвар 287,7 сая төгрөгөөр, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 11,0-11,8 сая төгрөгөөр, ойн төлбөрийн орлого 33,2 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 23,6 сая төгрөгөөр, хүү торгууль болон бусад орлого 50,6-68,8 сая төгрөгөөр тус тус давж биелсэн боловч ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ус ашигласны болон газрын төлбөрүүд 21,1-295,6 сая төгрөгөөр тасарсан нь энэ онд санхүү эдийн засгийн хямралтай уялдаж уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрүүдийн үйл ажиллагаа зогсож Алтандорнод монгол ХХК, Бэрэн Майнинг ХХК зэрэг олборлох үйлдвэрүүдийн үйл ажиллагаа зогссоноос орон нутгийн төсөвт орох орлого бүрэн төвлөрч чадахгүй байгаагаас шалтгаалж байна.

Дээрх орлогуудыг хэрхэн төсөвт төвлөрүүлж, хувиарлах талаар төсөв санхүүгийн шинэчлэл, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд нэгдсэн төсвийн тухай хууль, төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийг шинэчлэн найруулж байгаатай холбогдуулан хуулийн төсөлд санал хүргүүлсэн.

Бодит шалтгаанаар төсөвт төвлөрөөгүй мал бүхий иргэний орлогын албан татвар 170,0 сая төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 295,6 сая төгрөг, ус болон газрын төлбөрийн 57,4 сая төгрөгийн орлогууд 2009 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр тасарна гэж тооцоолон энэ талаар аймгийн ИТХТ-ийн хурлаар шийдвэр гаргуулж Засгийн газарт уламжлан Сангийн Яаманд удаа дараалан хүсэлт тавьж 523,0 сая төгрөгийн эх үүсвэр шийдвэрлэгдсэнээр орон нутгийн удирдлагын салбарын санхүүжилт бүрэн хийгдэж төрийн байгууллагуудын үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл бүрдсэн.

**Үйлдвэр хөгжүүлэх ажлын хүрээнд** 2009 онд үйлдвэрийг дэмжих санг 885,0 сая төгрөгөөр бүрдүүлэн уг сангаас зээл олгох төсөл сонгон шалгаруулах аймгийн дэд комиссыг байгуулан ажиллах журам, комиссын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих зөвлөлийг байгуулан ажиллуулж байна. Төсөл шалгаруулах комисст иргэд, аж ахуйн нэгжүүдээс 200 гаруй төсөл хүлээн авч шалгаруулан 119 төсөлд хөнгөлөлттэй зээл олгохоор аймгийн Зоос банкинд хүргүүлснээс 70 төсөлд 845,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг сарын 1 хувийн хүүтэй ,3 жилийн хугацаатай олголоо.

Мах, сүүний нийлүүлэлтийг тогтвортой байлгах зорилгоор Төвшрүүлэх суманд махны чиглэлийн “Сэлэнгэ” үүлдрийн фермерийн аж ахуй байгуулахаар 20 үнээ худалдан авч цэврээр нь үржүүлж, Ихтамир суманд хайнаг ,сарлагийн үнээг саамшуулж саалийн хугацааг уртасгах туршилтыг 15 сарлагийн үнээ, 10 хайнагийн үнээн дээр туршиж байна.

Аймагт “Цөм сүргийн үржлийн төв”-ийг байгуулж Хотонт, Тамир үүлдрийн хонь болон Сэлэнгэ үүлдрийн үхрийн цөм сүргийг бүрдүүлж цаашид фермерийн аж ахуйн хэлбэрээр ажиллуулахаар зохион байгуулж, дээрх үүлдрийн 25000 хонин сүрэгт хянан баталгаажуулалт хийсний зэрэгцээ нутгийн шилмэл омог хэвшлийн 8000 бод

малд үзлэг, ангилалт хийж ашиг шимийн үзүүлэлтүүдийг тогтоон бүртгэлжүүлж мэдээллийн санг бүрдүүллээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон хөтөлбөр, төслийн хөрөнгөөр 20 худгийг шинээр гаргаж төв, суурин газрын хүн амын болон бэлчээрийн усан хангамжийг сайжруулах арга хэмжээ авлаа. Үүний зэрэгцээ гар худаг гаргасан зарим малчдыг шагнаж урамшуулахад 950.0 мянган төгрөг зарцууллаа.

Газар тариалангийн салбарыг хөгжүүлэх “Атрын-III” аян хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд энэ онд 4000 га талбайд улаан буудай, 770.5 га талбайд төмс, хүнсний ногоо тариалж 2305-4386 тн ургац хураан авлаа. Өөрөөр хэлбэл үр тарианы талбай өмнөх жилийнхээс 2.1 дахин нэмэгдэж, хураан авсан ургацын хэмжээ 22 хувиар өссөн дүнтэй байна.

**Дэд бүтэц, барилга, хот байгуулалтын хүрээнд** Хархорин–Цэцэрлэгийн чиглэлд баригдаж байгаа хатуу хучилттай замын ажил энэ онд үргэлжлэн хийгдэж байгаа боловч ажил нь удаашралтай явагдаж байгаагийн зэрэгцээ Цэнхэр – Цэцэрлэгийн хооронд 9 км зам барих компани гэрээгээ цуцалсан тул дахин тендер зарлагдсан . Энэ чиглэлд “Архангай -авто зам”, “Алтайн зам” компаниуд 25 км хатуу хучилттай замыг энэ онд бариад байна. Харин Ихтамир – Солонготын чиглэлд ӨМӨЗО-ны зам барилгын 2 дугаар анги , “Хурдны зам”, “Монроуд” компаниуд үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр урьд онуудад хийгдсэн аймгийн төвийн цэвэр бохир усны шугамын ажлыг бүрэн дуусгаж 140 айлын амины орон сууц барих газрыг иргэдэд олгож, Эрдэнэбулган сумын IV-36 айлын орон сууцны дээвэр, IV-36, 27 айлын орон сууцнуудын гадна засварт 50.0 сая төгрөг зарцууллаа.

Эрдэнэбулган сумын өнгө үзэмжийг сайжруулж, нийтийн эзэмшлийн зам, талбайг гэрэлтүүлэх, хайс, хашааг шинэчлэх, гэрэлтүүлэг чимэглэл хийх, хүүхдийн парк тохижуулах зэрэгт 70,0 сая төгрөгийн ажил хийгдлээ.

Телевизийн нэвтрүүлгийн сувгийн тоог нэмэгдүүлснээр аймгийн иргэд 20 сувгаар телевизийн нэвтрүүлэг үзэх боломжоор хангагдсанаас гадна бүх сумдыг холбох шилэн кабелийн сүлжээ байгуулах инженерийн зураг, төсөв, тооцоог боловсруулах ажлыг эхлүүллээ.

**Байгаль орчныг хамгаалах ажлын хүрээнд** 2009 онд ногоон байгууламж бий болгох зорилгоор мэргэжлийн байгууллагын оролцоо дэмжлэгтэйгээр улсын төсвийн хөрөнгөөр 214 га-д, аж ахуй нэгж байгууллагын хөрөнгөөр 80 га-д нийт 294 га-д ойжуулалтын ажил хийгдээд байна.

Хот суурин газрыг цэцэрлэгжүүлэх, цөлжилтөөс хамгаалах зорилгоор 3 кг хайлаасны үр , 10.0 мянган ширхэг улиасны мөчирийг мод үржүүлгийн газар тарьж ургуулж байгаагаас ургалт 70 хувьтай байна.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2009 онд Аймгийн засаг даргын 01 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж ажиллав.

Аймгийн зүгээс Мэргэжлийн хяналтын газар, хууль хяналтын байгууллагуудтай хамтран ойн хуулийн хэрэгжилтийг шалгах байнгын хуваарь гарган ажилласны үр дүнд мод хулгайгаар бэлтгэж тээвэрлэх явдал урд онуудтай харьцуулахад 10 орчим хувиар буураад байна.

Байгаль хамгаалах чиглэлээр сумдад “ Ойн нөхөрлөл ” байгуулах ажлыг эхлүүлж, одоогийн байдлаар 57 ойн нөхөрлөл ажиллаж байна. Нөхөрлөлийн гишүүн 94 хүнийг 2 удаагийн сургалтанд хамруулсан байна.

Аймгийн төвийн түлшний хэрэгцээг хангах зорилгоор мэргэжлийн байгууллагыг түшиглэн ой цэвэрлэх журмаар түлшний мод бэлтгэх түлшний зах байгуулан идэвхитэй ажил хайж байгаа ажилгүй иргэдийг ажлын байраар хангах арга хэмжээг зохион байгуулж 540 м<sup>3</sup> түлш бэлтгэсэн байна.

Байгалийн үзэсгэлэнт газар, соёл, түүхийн дурсгалт газруудыг сум орон нутгийн хамгаалалтанд авах бүсийг тогтоох, мэдээллийн санг бүрдүүлэх талаар сум орон нутагтай хамтран ажиллаж байна.

Энэ онд рашаан усны тооллогыг аймгийн хэмжээнд хийж бүх рашааны дээжээс сорьц аван Усны газарт хүргүүлж 14 сумын ус ашиглагч аж ахуй нэгж байгууллагуудын ус ашиглалтын болон хөдөө аж ахуйн усны хэрэглээг гео-мэдээллийн санд оруулсан байна.

Аймгийн төвийн орон сууц, аж ахуй нэгж байгууллагуудын цэвэр усны хэрэглээг тоолууржуулснаар усыг хэмнэлттэй зарцуулах, зохистой хэрэглэх боломж үндсэндээ бий болж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр долоон булаг хашиж хамгаалж, иргэд, аж ахуй нэгж байгууллагын оролцоотойгоор 40 гаруй булгийн эхийг хамгаалаад байна.

Аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний албаны дэргэдэх цаг агаарт зориудаар нөлөөлөх “Бороо-8” экспедицийн үйл ажиллагааг өргөжиж, албан ажлын хэрэгцээний фургон машинаар хангагдсан байна.

Аялал жуулчлалын баазуудад мэргэжлийн байгууллагуудтай хамтран аттестатчилал хийж үйлчилгээний стандарт хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч байна.

2009 оны 1 дүгээр сард сумын Засаг дарга нарын саналыг үндэслэн 19 суманд 20 газрын даамлыг томилон ажиллуулж байна.

Шинээр газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу ил тод нээлттэй зохион байгуулснаар 15 сумын нутаг дэвсгэрт 42 удаагийн дуудлага худалдаа явуулж гэрээний үүргээ биелүүлсэн иргэн, аж ахуйн

нэгж байгууллагад үйлдвэрлэл, үйлчилгээ, үр тариа, төмс хүнсний ногооны зориулалтаар нийт 126.1 га газрын газар эзэмших эрхийн үнийг 53.0 сая төгрөгөөр худалдаж орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

Газрын кадастр, бүртгэл зураглалын ажлыг сайжруулах зорилгоор Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр аймгийн 19 сумын хот суурины төв, тариалангийн болон атаршсан газарт кадастрын зураглал ба бүртгэлийн ажлыг хийж гүйцэтгэснээр газрын мэдээллийн сантай болсон байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагууд аймгийн хэмжээнд согтууруулах ундаа үйлдвэрлэж, худалдаж байгаа 513 цэг, салбарт давхардсан тоогоор 134 удаа шалтгалт хийж 35 цэг, салбарын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, 19 цэг салбарын тусгай зөвшөөрлийг 1-3 сарын хугацаагаар түдгэлзүүлэх, 145 цэг, салбарын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах асуудлыг шийдвэрлэлээ.

Аймгийн хэмжээнд сүүлийн 10 жилд гарсан гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг судалж цаг үеийн нөхцөл байдалд тохирсон цогц арга хэмжээнүүдийг шат дараатайгаар авч хэрэгжүүлсний үр дүнд энэ оны 11 сарын байдлаар гэмт хэрэг 33 хувиар, гудамж талбай олон нийтийн газар үйлдэгдсэн гэмт хэрэг 7 хувиар, насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг 67.4 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол 22.6 хувиар тус тус өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна.

Төрийн архивт мэдээлэлийн технологийг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд 29 хөмрөгийн данс бүртгэлийг хадгаламжийн нэгжийн бүртгэлтэй тулган нягтлан шалгаснаас гадна шаардлагатай 5 хөмрөгийн баримтанд эрдэм, шинжилгээ техник боловсруулалтын ажлыг хийж баримтын мэдээллийн түвшин, асуулгаас хамааруулан сан хөмрөгүүдийн зэрэглэлийг шинэчлэн тогтоосон байна.

Энэ онд улсын хэмжээнд зохион байгуулагдсан архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгээр “сайн” үнэлгээтэй дүгнэгдлээ.

Аймгийн нэгдсэн Веб сайтыг шинэчлэж дуусаад туршилтын ажил хийгдэж байна. Ирэх оноос интернетэд байршуулан ашиглаж эхэлнэ. Ингэснээр төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, аймаг, орон нутгийн талаарх мэдээ, мэдээлэл олон нийтэд нээлттэй болж иргэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүртэх шинэ орчин нөхцөл бүрдэнэ.

Энэ жил онцгой байдлын хэлтсийг 27.7 сая төгрөгийн автомашин, гал унтраах зориулалтын багаж хэрэгслээр хангах арга хэмжээг авсан байна.

Гамшгаас хамгаалах сургалтанд сумдын хүнс, хөдөө аж ахуйн мэргэжилтэн, малын эмч, сумын Засаг даргын Тамгын газрын дарга, байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч нар хамрагдсан бөгөөд Төвшрүүлэх, Өгийнуур суманд команд штабын иж бүрэн сургалтыг зохион байгууллаа.

Аймаг , орон нутгаа гадаад орнуудад сурталчлан таниулах , харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх нь гадаад харилцаанд баримтлах гол чиглэл юм.

Манай аймаг БНХАУ-ын Элчин сайдын яам ,ӨМӨЗО-ны Баяннуур хотын Урадын хойд хошуу, Зүүн хойд Азийн бүс нутгийн засаг захиргаадын холбоотой байнгын харилцаатай ажиллаж байна.

Энэ онд Зүүн хойд Азийн бүс нутгийн засаг захиргаадын холбооны хуралд аймгийн төлөөллийг оролцуулсан бол аймаг, сумын ИТХ-ийн нарийн бичгийн дарга нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид Эрээн, Бээжин, Хөх хотуудын нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаатай нь танилцаж туршлага судаллаа.Мөн БНХАУ-ын Эрээн хот,Баяннуур хотын Урадын хойд хошууны Ардын Засгийн газрын урилгаар манай хурал, төрийн байгууллагын төлөөлөгчид ажлын айлчлал хийж хамтын ажиллагааны талаар санал солилцож ирэх онд гэрээ байгуулахаар тохиролцсон байна.

Аймгийн Засаг даргын ивээл дор “ Монголын Хятад судлал-Монголын хөгжлийн гарц “ сэдэвт чуулга уулзалтыг аймагтаа зохион байгуулж чуулга уулзалтанд 50 орчим төлөөлөгч оролцон 20 гаруй илтгэл тавьж, зөвлөмж гаргалаа.

## **Гурав. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ**

### ***1. Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхий захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт***

Монгол Улсын Шадар сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, ХЗДХ-ийн сайд, Үндэсний статистикийн хороо, Батлан хамгаалахын сайд, Хүнс,хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Боловсрол соёл шинжлэх ухааны сайдуудтай аймгийн Засаг дарга бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээний байгуулан ажилласан.

Гэрээний биелэлтийг холбогдох яамдуудад нь тогтоосон хугацаанд хүргүүлж ажиллалаа. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Үндэсний статистикийн хороо, Хүүхдийн төлөө газраас гэрээний биелэлтийг хангалттай биелүүлсэн гэж үзэж дээрх агентлагуудын дарга нарыг шагнаж урамшуулах талаар санал ирүүлсэн байна. Бусад сайдуудаас нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээний биелэлтэнд үнэлэлт дүгнэлт өгсөн үнэлгээг одоогоор ирүүлээгүй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудаас аймгийн Засаг даргатай байгуулсанбүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн 2009 оны гэрээний биелэлтэнд үнэлэлт дүгнэлт өгсөн үнэлгээг хавсаргав.

### ***2. Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт***

Аймгийн Засаг даргын Тамгын Газрын төсвийн ерөнхий менежер нь Тамгын Газрын жилийн ажлын төлөвлөгөөнд 94 бүтээгдэхүүнийг нийлүүлэхээр гэрээгээр

үүрэг хүлээснээс 88 бүтээгдэхүүнийг бүрэн нийлүүлж, 4 бүтээгдэхүүнийг хагас биелүүлж, 2 бүтээгдэхүүн тасарч 94,6 хувийн биелэлттэй гүйцэтгэсэн байна.

Нийлүүлсэн бүтээгдэхүүнийг тоймлон танилцуулбал:

Аймгийн ЗДТГазар, хэлтэс, тасаг, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагуудаас санал захиалга авч зохицуулалт хийн нэгдсэн хуваарь боловсруулан Засаг даргаар батлуулан мөрдөж 2009 онд төрийн байгууллагын албан хаагчдын дунд 39 удаагийн сургалт семинар, зөвлөлгөөнийг аймагт зохион байгуулж давхардсан тоогоор 1450 гаруй албан хаагч оролцсон байна.

Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж 2010 оны 1-р сарын 01-нээс эхлэн мөрдөхөөр Засаг даргаар батлуулан сумдад хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн батлагааны хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэлтэс тасаг, албан хаагчдаас саналыг авч тусган батлан гаргалаа.

ТАСЗ-д Хашаат, Хангай, Хотонт, Өгийнуур, Цахир сумдын Засаг даргын Тамгын Газрын дарга, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга, тээвэр авто замын газрын даргын сонгон шалгаруулалтуудыг журмын дагуу явуулж, тэнцсэн иргэдийг удирдах ажилтны нөөцөд бүртгэн нэр дэвшүүлж, томилгоо хийлгүүлэх ажлыг зохион байгууллаа.

Төрийн албаны мэргэшлийн шалгалтыг 3 удаа зохион байгуулан явуулж холбогдох мэдээ тайланг ТАЗ-д тухай бүр гарган өгснөөр багийн Засаг даргын нөөцөд 481, төрийн захиргааны албан тушаалын нөөцөд 161 иргэн бүртгэгдэж тэднээс 46 нь төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон.

ТАСЗ-д Өгийнуур сумын ЗДТГ-ын нийгмийн ажилтан Д.Ганчимэг, ХХҮХ-ийн мэргэжилтэн Б.Нэргүй, Чулуут сумын ЗДТГ-ын дарга Ц.Лонжидпил, Хайрхан сумын ЗДТГ-ын ажилтан Ч.Чулуунбаяр, Өлзийт сумын ЗДТГ-ын дарга Д.Амарсайхан, Төвшрүүлэх сумын ЗДТГ-ын дарга Өлзийжаргал нараас ирүүлсэн гомдол өргөдлийг комисс томилон шалгуулж дүгнэлт гаргаж хуульд нийцүүлэн шийдвэрлүүлсэн.

Төрийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг хөнгөн шуурхай болгох, ард иргэдэд чирэгдэлгүй үйлчлүүлэх үүднээс Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Хүний эрхийн судалгааны төвтэй хамтран “Нэг цонх-ны үйлчилгээг 2009 оны 7 дугаар сараас нээн ажиллуулж байна.”Нэг цонх “-ны үйлчилгээний байрыг засварлаж тохижуулахад орон нутгийн төсвөөс 7.0 сая төгрөг зарцууллаа.

Энэхүү “Нэг цонх” -оор өдөрт дунджаар 80 иргэнд нийгмийн халамж, иргэний бүртгэл мэдээлэл, нийгмийн даатгал, газрын харилцааны чиглэлээр төрийн үйлчилгээг хүргэж банк, нотариат зэрэг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж иргэдэд үйлчилж байна.

Засаг даргын дэргэдэх агентлагууд болон сумдын Засаг дарга нарын 2008 оны ажил, Менежерийн гэрээний биелэлтэнд үнэлгээ өгч Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, дүгнэлт гарган, шинээр байгуулах бүтээгдэхүүн нийлүүлэх санхүүжилтийн гэрээний төслийг боловсруулж нэгтгэн, гэрээг байгуулан баталгаажуулсан.

Шинээр сонгогдсон Засаг дарга, ИТХ-ын тэргүүлэгчдийн дарга нарт нутгийн захиргааны байгууллагын онцлог, ажил үүргийн уялдааны тухай хичээл зааж, эрх зүйн лавлагааны эмхэтгэл боловсруулж гарын авлага болгон өглөө.

ХШҮ-ий тасгаас 8 агентлагийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг удирдамжийн дагуу хийж, дүгнэлт өгч, газар дээр нь зөвлөмж өгч ажилласан.

18 суманд аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг хийж, Сум, агентлагуудад Засгын газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл, аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөрүүд, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах талаар зохиож буй ажлыг газар дээр нь шалган зөвлөх ажлыг зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын Газарт 2009 онд ирүүлсэн 238 өргөдөл гомдлын 63 нь лиценз зөвшөөрөл буюу 26.4 хувь, 52 нь мөнгөн тусламж буюу 21.8 хувь, гэр орон сууцтай холбоотой 30 буюу 12.6 хувь, орон нутгийн төрийн захиргааны байгууллага, ажилтнуудын шийдвэр үйл ажиллагаатай холбоотой 21 буюу 8.8 хувь, ажилд орох 23 буюу 9.6 хувь, үлдсэн 49 буюу 20.5 хувь нь бусад асуудлаар хандсан байна.

Эдгээрээс 216 нь хугацаандаа шийдвэрлэгдэж, хугацаа болоогүй 15 байна.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 14 удаа хуралдаж аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудын 2008 оны үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх тухай, Аймгийн сайн малчин, мянгат малчин шалгаруулах тухай, гар худаг гаргах уралдааны болзол дүгнэх тухай, бэлчээрийн менежментийн загвар сум шалгаруулах тухай, Тогтвортой амьжиргаа II төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр сумдаас ирүүлсэн төслүүдэд ОНС-ын ажлын хэсгийн хийсэн дүгнэлт зэрэг 30 гаруй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Архангай аймаг нь дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудын муж хот болох БНТУ-ын Аядин муж, БНСУ-ын Чон Ян хот, Франц улсын Флейзр хот, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Баяннуур аймгийн Урад хойд хошуу, Шандун мужийн Лаолин зэрэг хотуудтай ах дүүгийн хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлж байна.

Аймгийн хэмжээнд жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэхэд Орон нутгийн түүхий эдийн хангалт, Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ, зах зээл, тухайн орон нутагт урьд өмнө бий болсон үйлдвэрлэлийн бааз суурь, уламжлалт арга, ажиллах хүчний нөөц бололцоо, санхүүгийн чадавх зэргийг судлан үзсэний үндсэн дээр Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 64 дүгээр тогтоолоор баталсан Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр, 2009 оны 178 дугаар тогтоолоор баталсан орон нутагт

үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих, шинээр байгуулах зорилтуудтай уялдуулан аймгийн хэмжээнд байгуулж болох жижиг, дунд үйлдвэрийн чиглэлийг боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн, байгаль орчин, аялал жуулчлалын ажилтны, аймгийн манлай малчдын, тариалан эрхлэгчдийн, мал аж ахуйн мэргэжилтнүүдийн, барилгын салбарын инженер, техникийн ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх сургалт, семинарийг 1-2 удаа зохион байгуулж ажиллалаа.

Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж инженерийн хийцтэй худаг 15-ийг шинээр гаргах, Цөм сүргийн үржлийн төвийг байгуулж Сэлэнгэ үүлдрийн 18 үхэр, илүү нуруу нугаламтай 500 гаруй хонь бүхий үржлийн цөм сүргийг бүрдүүлэн “Тамир”, “Сэлэнгэ” үүлдрийн хэсгийн хонь, үхрээр цөм сүрэг бүрдүүлэх ажлыг зохион байгуулав.

Малын чанар сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж “Тамир”, “Хотонт” хонинд үзлэг ангилалт хийж цөм сүргийг бүрдүүлэн хянан баталгаажуулалтыг 12 сумын 25000 бог малд хийлгэж шилмэл омог хэвшлийн мал үржүүлэх, өндөр ашиг шимтэй сүү, махны чиглэлийн үхрийн фермерийн аж ахуй байгуулах төслийг сонгон шалгаруулж 6 иргэн, аж ахуйн нэгжид 110,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгон дэмжлэг үзүүлж ажиллав.

Энэ онд газар тариалангийн салбарыг хөгжүүлэх “Атрын 3 дахь аян” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 4000 га талбайд үр тариа тариалж 2305 тн улаан буудай, 770.5 га талбайд төмс, хүнсний ногоо тариалж 4386 тн ургац хураан авах ажлыг зохион байгуулж ажилсны дүнд хураан авсан үр тарианы хэмжээ урьд оныхоос 22 хувиар өссөн дүн гарч байна.

Ойн хортонд хүчтэй нэрвэгдсэн Эрдэнэмандал, Өндөр-Улаан, Тариат, Эрдэнэбулган сумдын 14000 га-д, бэлчээрийн огтоно устгах ажлыг 3 суманд 55000 га талбайд авиа химийн аргаар, 8 суманд 35000 га талбайд механик болон биологийн аргаар устгах ажлыг зохион байгуулав.

Улсын төсвийн хөрөнгөөр ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг 285 га-д 57,8 сая төгрөгөөр, Хасу мандал, Ар-Шинэс, Ар-Тээл, Тэлээ таван хайрхан, Цогт-Уянга зэрэг аж ахуйн нэгжүүд өөрийн хөрөнгөөр 80 шахам га-д байгалийн сэргээн ургалтыг дэмжих ажлыг хийлгэлээ. Жаргалант, Эрдэнэмандал, Хангай сумдын Засаг даргын Тамгын Газруудын конторын барилгуудын засваруудын ажлыг холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлэв.

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин төсөл сонгон шалгаруулах замаар 70 төсөлд 845,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, энэ хүрээнд шинээр 9 жижиг, дунд үйлдвэр, цех байгуулагдаж, 186 байнгын ажлын байраар хангах арга хэмжээ авлаа.

Аймгийн Засаг дарга 2009 онд нийт 446 захирамж гаргаснаас захирамж бүрийг төслөөр нь холбогдох удирдлагуудаас саналыг нь авсны үндсэн дээр эцсийн санал, дүгнэлтийг гаргасан байна.

Зургаан сумын 500 гаран захирамжийг татан хянаж аймгийн Засаг даргын захирамжаар 6 захирамжийг хүчингүй болгуулж, хууль тогтоомж зөрчиж гарсан 58 захирамжийн зөрчлийг өөрсдөөр нь арилгуулахаар зөвлөмж хүргүүлж биелэлтийг нь тооцон ажилласан байна.

Төлбөрийн чадваргүй иргэдээс гаргасан хүсэлтийг хүлээн авч, 31 хэрэгт холбогдох 34 сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид өмгөөллийн туслалцааг үнэ төлбөргүй үзүүллээ. Хэрэгт холбогдогчдын ял шийтгэлийн байдлыг авч үзвэл хорих ялаар-21, торгох ялаар-4, Баривчлах ялаар 6, Албадан ажил хийлгэх ялаар-3 хүн тус тус шийтгэгдсэн байна.

Зарим аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар энэ онд 17 сэдвийн хүрээнд 243 иргэнийг хамарсан эрх зүйн албан бус сургалтыг зохион байгуулж явууллаа.

2009 онд архивын нөхөн бүрдүүлэлтийг төлөвлөгөөний дагуу 26 хөмрөг үүсгэгчийн 1089 хадгаламжийн нэгжээр сан хөмрөгөө баяжуулсан нь өмнөх онтой харьцуулахад 241 хадгаламжийн нэгжээр нэмэгдсэн байна.

2009 онд 19 хөмрөгийн 1835 хадгаламжийн нэгж, баримтанд нягтлан шалгалт, дахин боловсруулалт хийснээс гадна сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор архивын 26 хөмрөгийн 1989 хадгаламжийн нэгжид хэсэгчилсэн буюу иж бүрэн тооллого явуулж, 2135 хадгаламжийн нэгжид сэлбэн засах ажиллагааг гараар гүйцэтгэлээ.

Төрийн архивын баримтыг ашиглуулах журмын дагуу энэ онд 1319 иргэд, байгууллагыг хүлээн авч уулзан санал бодлыг сонсон судлаж хариуг биечлэн өглөө. Мөн 112 судлаач эрдэмтэн, иргэд, байгууллагад үйлчилж нийтдээ 948 хадгаламжийн нэгжийг мэдээлэл лавлагаанд ашиглуулсан байна.

Монгол улсын Засгийн Газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 50000 өрхийг ядуурлаас гаргах, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт ядуурлын түвшинг 25.0 хувьд, ажилгүйдлийн түвшинг 2.5 хувьд хүргэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд “Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах” аймгийн хөтөлбөр боловсруулан, жил бүр аймгийн хэмжээнд ядуурлаас гаргах өрхийн тоог сум бүрээр гарган аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж байна.

**Эрүүл мэндийн салбарын хүрээнд:** Эрүүл мэндийн салбарын хөгжлийн зөвлөгөөнийг Эрүүл мэндийн яамтай хамтран зохион байгуулж аймгийн “Эрүүл мэндийн салбарын хөгжлийн дунд хугацааны /2010-2015 он/ стратеги төлөвлөгөө” -г боловсруулан хэлэлцүүлэн батлуулсан бөгөөд цаашид улсын хэмжээнд бүх аймаг, дүүргүүдэд уг зөвлөгөөнийг зохион байгуулах жишиг туршлага боллоо.

Энэ онд манай эрүүл мэндийн салбарт сүүлийн 30 жилд хийгдээгүй томоохон хөрөнгө оруулалтын асуудлууд шийдэгдэж бусад дэмжлэг хамтын ажиллагааны эхлэл тавигдлаа. Тус аймагт 600.0 сая төгрөгийн өртөг бүхий 30 ортой Халдвартын эмнэлгийн барилгыг ашиглалтанд оруулж, Эрүүл мэндийн газар, Ихтамир, Өлзийт сумдын эмнэлгийн барилгын засварт нийт 45.0 сая төгрөг зарцуулсан байна. Мөн

хүүхдийн эмнэлгийн барилгыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 500.0 сая төгрөгөөр бариулж ашиглалтанд хүлээн авахад бэлэн болоод байна.

Дэлхийн зөн олон улсын байгууллагын Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хүүхдийн хоол тэжээл” хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн хоол тэжээлийн суурь судалгааг хийж нийт сум, өрхийн эмнэлгийн түвшинд 600 гаруй өрх, гэрийн бүлийг хамруулан, аймгийн хэмжээний 0-5 насны нийт хүүхдэд эрүүл мэндийн үзлэг хийн хооллолтын байдалд үнэлгээ өгч, эмнэлгийн ажиллагсад болон эцэг эхчүүдэд сургалт хийсэн байна. Сумдын эмнэлэг, эхийн амрах байрыг түшиглэн “Эх хүүхдийн хоол тэжээлийн сан”-г байгуулахаар зохион байгуулсны дагуу Батцэнгэл, Төвршүүлэх, Хотонт, Хайрхан, Өндөр -Улаан, Булган, Цэцэрлэг сумдад эхлэлийг тавиад байна.

Биеийн тамир спортыг хөгжүүлэх зорилтын хүрээнд Бөх, болейболын спортоор төрөлжсөн сургалттай анги сургууль байгуулан Улсын аварга шалгаруулах болон Олон улсын тэмцээнээс алт, мөнгө, хүрэл медаль 52 ширхэгийг авч, Спортын мастер-2, дэд мастер-4, зэрэгтэй тамирчид олноор төрсөн байна.

Бүх нийтийн алхалт гүйлтийн арга хэмжээг автомашингүй өдөртэй хамтатган зохион байгуулж энэ арга хэмжээнд 74 байгууллагын 14350 гаруй хүн хамрагдаж идэвхтэй хөдөлгөөнд орлоо. Нийтийг хамарсан спортын уралдаан тжмцээн, арга хэмжээг 32 удаа зохион байгуулж 137 байгууллагын 8724 хүн оролцсон байна.

**Боловсролын салбарт:** Сургалтын орчинг сайжруулах чиглэлээр 6 настай хүүхдийн суралцах загвар ангиудын бүсийн төв ЭБ сумын Хүмүүн-1 сургууль, Хотонт, Эрдэнэмандал, Тариат сумын ахлах 4 сургуульд тус бүр 5.0 сая төгрөгийн, “Үр дүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл” хөтөлбөрөөс 12 бүлэгт 22848.9 мянган төгрөг, Дэлхийн Зөн олон улсын байгууллагаас 44 бүлэгт 73902.0 мянган төгрөгийн ширээ сандал, самбар, номын тавиур, зэргийг нийлүүлсэн байна.

Тайлант онд боловсролын салбарын материаллаг баазыг бэхжүүлэх, сургалтын орчин нөхцлийг сайжруулах талаар хөрөнгө оруулалтын томоохон ажлууд хийгдлээ. ЭБ сумын 4-р сургууль, Ирээдүй цогцолбор, БСГ, Батцэнгэл, Өгийнуур сумын сургуулийг шилэн кабелиар интернэтэд, Тариат, Цэнхэр, Ихтамирын сургуулийг VISAT-аар интернэтэд холбосон байна. Энэ онд англи хэлний 31 багш вакуумжуулсан, ерөнхий боловсролын сургуулийн 40 багш зайн сургалтанд хамрагдаж Багшийн коллеж, Эрдэнэбулган сумын “Хүмүүн” цогцолборын 1,2, 3-р сургуулиудад англи хэлний иж бүрэн онлайн кабинетийг байгууллаа.

“Үдийн цай” хөтөлбөрийг өргөжүүлэн “Үдийн хоол” болгон 7 хоногийн 2-5 өдөрт халуун хоол өгдөг болоод байна. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн өдрийн ангид 1357 оюутныг элсүүлэн, 408 оюутныг 2.5 болон 1 жилийн сургалтаар төгсгөснөөс 66.4 хувь нь ажлын байртай болсон буюу их дээд сургуульд дэвшин суралцсан байна.

Аймгийн нийтийн номын сан болон сум, сургуулиудын номын сангийн фондыг 109.5 сая төгрөгийн 11365 ширхэг номоор баяжуулсан байна. Мүзейн зарим үзмэрийг сэргээн засварлаж олон жил фондод хадгалагдаж байсан үзмэрийг үзмэрийн

танхимд шилжүүлэн шинэчлэн зохион байгуулж аймгийн төвд 4 удаа, Баянхонгор, Өвөрхангай, Хархорин зэрэг аймгуудад нүүдлийн үзэсгэлэн гаргаж 10 000 гаруй иргэд, гадаадын жуулчдад түүх соёлын үнэт болон дурсалт зүйлийг сурталчилсан байна.

**Нийгмийн хамгааллын чиглэлээр:** ХЯБХ-ийн Нийгмийн хөгжлийн дэд хэсгийн хүрээнд Цэцэрлэг, Төвшрүүлэх, Булган, Ихтамир сумдад ХАС банкаар дамжуулан нийгмийн эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн 16 бүлэгт 27313.0 мян төгрөгний зээл олгосон байна.

Зээлийн хүрээнд эмэгтэйчүүд жижиг бизнес, газар тариалан, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйлдвэрлэл явуулж нийт 70 хүн түр болон байнгын ажлын байраар хангагдсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрт орон нутгийн төсвөөс 2.5 сая төгрөг, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас хэрэгжүүлж байгаа Хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 7 төсөлд 19.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж 35 хүн үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж ажлын байраар хангагдсан байна.

“Хүнс тэжээл, нийгмийн халамжийн хөтөлбөр”-т 1742 иргэнийг хамруулахаар сумдын “Амьжиргааг дэмжих зөвлөл”-өөр хэлэлцүүлэн баталж 11 сараас эхлэн хүнсний бүтээгдэхүүнийг иргэдэд олгож эхлээд байна

Төрийн зарим чиг үүргийг Иргэний нийгмийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын хүрээнд Нийгмийн халамжийн сангаас Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 9 Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж 31.6 сая төгрөгний, Хөдөөгийн Агрибизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд ТББ-ын чадавхийг бэхжүүлэх зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоонд -5.0 сая. төг, Шинэ эхлэл холбоонд- 5.0 сая.төг, Үндэсний холбоонд -6.5 сая. төг, Хэвлэл мэдээллийн төвд- 5.0 сая төг, Мэдээлэл гэгээрлийн Ай-И-Си төвд- 4.8 сая төг, Багш эцэг эхчүүдийн нийгэмлэгт 9.1 сая төгрөг нийт 34.0 сая төгрөгний санхүүгийн буцалтгүй дэмжлэг үзүүлсэн байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 56087 хүнд 7186.1 сая төгрөгний тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээ олгосон нь **нийт хүн амын тоотой харьцуулбал 62,8 хувь нь** төрийн халамж үйлчилгээнд хамрагдаад байна.

Аймгийн ЗДТГ, МХГ, НДХ, Татварын хэлтэс хамтран аймгийн төв болон 10 сумын нийт давхардсан тоогоор 161 байгууллага, ААН, 32 цэг салбарын 2260 ажиллагсдыг хамруулан ажиллагсдын цалинг хөлс тогтоолт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөд хяналт шалгалт хийж, Шалгалтын явцад 160 зөрчил дутагдал илэрсний 101-ийг газар дээр нь арилгуулж, улсын байцаагчийн 37 албан шаардлага, 5 акт, 2 дүгнэлтээр хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласнаар 84.4 хувийн биелэлттэй байна.

Сумдын Засаг дарга болон төрийн сангийн төлөөлөгч нарт төсвийг зөв менежментээр удирдаж үр ашигтай зарцуулах, хэмнэлтийн горимд шилжих чиглэлээр 3 удаа семинар өгч, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, өр авлага үүсгэхгүй ажиллах чиглэлээр сургалт, семинар зохион байгуулж, зөвлөмж зааварчилга болон хэрэгжүүлж гүйцэтгэх ажлын чиглэл өгч ажиллалаа.

Дээрхи зохион байгуулсан ажлын үр дүнд 2009 онд удирдлагын салбарт 3785.4 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийж орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 102.2 хувиар буюу 60.1 сая төгрөгөөр давж биеллээ.

Тайлант хугацаанд улсын төсвийн байгууллагуудад 19349.4 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгээд байна.

Засгийн Газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд холбогдоогүй байсан Батцэнгэл, Өгийнуур сумдыг холбосноор бүх сумдын төрийн санг Засгийн Газрын УМС-ийн нэгдсэн сүлжээнд хамруулан үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

2. Аймгийн Засаг даргын Тамгын Газрын төлөвлөгөөнд тусгагдсан нийт 94 бүтээгдэхүүнээс 5 бүтээгдэхүүнийг тусгай захиалгат бүтээгдэхүүн болгон гэрээнд заасан бөгөөд эдгээрийг бүрэн биелүүлж нийлүүлсэн болно.

-Тамгын Газрын дэргэд Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн санхүүжилтээр хүний аюулгүй байдлын судалгааны төвийн дэмжлэгтэйгээр “Нэг Цонхны үйлчилгээний төв” нээн ажиллуулж байна.

-Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудаас 8 агентлагийн ажилтай танилцаж, хяналт, шинжилгээ үнэлгээ хийж дүгнэлт гарган, зөвлөлгөө өгөв.

-18 сумын Засаг даргын Тамгын Газрын ажилтай газар дээр нь танилцаж, зөвлөн туслав. Сумд, агентлагуудын ажлын тайланд хагас, бүтэн жилээр ХШҮ хийж зөвлөмж өгсөн.

-Үйлдвэржүүлэлтийг дэмжих жилийн ажлын хүрээнд “Архангай түншлэл -2009” үзэсгэлэн худалдааг аймгийн төвд зохион байгуулав.

-Жижиг дунд үйлдвэрийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулав.

3. Өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх талаар гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн . Үүнд :

- Мөнгөн хөрөнгийн зориулалтын дагуу зарцуулсан. Ямар нэг өр авлагагүй ажиллав. Орон нутгийн удирдлагын салбарт 3785,4 сая төгрөгийн санхүүжилт хийж, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 60,1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн.

-Биет хөрөнгийн нөөцийн ашиглалтыг сайжруулж, Тамгын газрын бүх мэргэжилтнийг компьютертэй болгов.

Аймгийн ИТХ-ын ажлын албаны ажиллах нөхцөлийг сайжруулахад 105,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийв.

-Боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, 39 удаагийн сургалт, семинарт 1450 гаруй төрийн албан хаагчдыг хамруулав.

4. Манлайлах ур чадвар, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх талаар 8 агентлаг, 18 сумын Засаг даргын Тамгын газрын ажилд ХШҮ хийж зөвлөмж өгсөн.

-Аймгийн Засаг даргын Тамгын Газрын хувьд “Төрийн албан хаагчдын сургалт”, “Төрийн албан хаагчдын аж байдал, нийгмийн хамгаалал” хөтөлбөрүүдийг шинэчлэн батлаад мөрдөж байна.

5. Засаг даргын Тамгын Газраас төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн 3 хүнд арга хэмжээ авч хариуцлага тооцсон.

6. Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 13,14,17,41 дүгээр зүйлүүдийг ямарч зөрчилгүй гүйцэтгэж ирсэн болно.

## **Дөрөв . Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ**

### **1. Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал**

Төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангаж, төрийн үйлчилгээг хэрхэн үзүүлж байгаа талаар аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг 2009 оны 11-р сард 19 суманд зохион байгуулж, шалган үүрэг зөвлөгөө өгөв.

Аймгийн ЗДТГ-аас Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолд заасан шалгуур үзүүлэлтийн биелэлтийг байгууллагуудаас гаргуулан хэрэгжилтийг тооцон, дүгнэлт гаргалаа.

Нийт байгууллагууд өөрийн байгууллагын эрхэм зорилгоо ил тод бичиж байрлуулан, мэдээллийн самбар ажиллуулан төрийн үйлчилгээ үзүүлэх жагсаалыг гаргаж, Мэргэжлийн хяналтын газар , Эрүүл мэндийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Боловсрол соёлын төв зэрэг газрууд нээлттэй утас ажиллуулан иргэдийн санал хүсэлтийг авч ажиллаж байна.

Эрүүл мэндийн газар, Боловсрол,соёлын газрууд байгууллагынхаа үйл ажиллагаа, нээлттэй байдлын талаарх сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр 10 сард авч дүнг ил тод танилцуулан түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээг авч хэвшүүлсэн байна.

Аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга, агентлагийн дарга нартай 2010 онд байгуулсан үр дүнгийн гэрээнд Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоол /

төрийн үйлчилгээний ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг батлах тухай/-ыг хэрэгжүүлэх асуудлыг нэг бүтээгдэхүүн болгон тусгаж өгөв.

Төрийн байгууллага нээлттэй, иргэдийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд тавих хяналтад ахмад, эмэгтэйчүүд, залуучууд, үйлдвэрчин, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж тэдний санал санаачилгыг бодлого шийдвэртээ тусган хэрэгжүүлэх, гэрээгээр зарим ажил үүрэг гүйцэтгүүлэх, мэдээллээ харилцан солилцох зэргээр хамтран ажиллаж байна.

Мерси Кор төслөөр Цэнхэр, Өлзийт, Хашаат сумдын хөгжлийн хэтийн мастер төлөвлөгөө боловсруулах ажил гүйцэтгүүлж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг төрийн бус байгууллагуудаар, зарим үзлэг шинжилгээг хувийн хэвшлийн эмнэлэгүүдээр, байгаль хамгаалах ажлыг иргэдээр гэрээгээр гүйцэтгүүлэн энэ арга хэмжээнд орсон нутгийн төсвөөс 12,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

Иргэдийн гомдол, санал, өргөдөл, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх ажлыг хуулийн хүрээнд явуулж ирлээ. Аймгийн Засаг дарга долоо хоногийн баасан гариг бүр иргэдтэй уулзаж санал хүсэлтийг авч судлан шийдвэрлэдэг.

Тайлангийн хугацаанд аймгийн ЗДТГ-аас 63 иргэн, аж ахуйн нэгжид лиценз олгох хугацааг сунгах үйлчилгээ үзүүлж, 32 хүнд 1780000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон байна.

Албан байгууллагууд “Нээлттэй хаалганы өдөр” явуулж иргэдэд үйлчилгээ үзүүлж тэдний санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх ажлыг зохион байгуулж хэвшсэн.

Төрийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг хөнгөн шуурхай болгох, ард иргэдэд чирэгдэлгүй үйлчлүүлэх үүднээс Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Хүний эрхийн судалгааны төвтэй хамтран “Нэг цонх-ны үйлчилгээг 2009 оны 7 дугаар сараас нээн ажиллуулж байна.”Нэг цонх “-ны үйлчилгээний байрыг засварлаж тохижуулахад орон нутгийн төсвөөс 7.0 сая төгрөг зарцууллаа.

Энэхүү “Нэг цонх” -оор өдөрт дунджаар 80 иргэнд нийгмийн халамж, иргэний бүртгэл мэдээлэл, нийгмийн даатгал, газрын харилцааны чиглэлээр төрийн үйлчилгээг хүргэж банк, нотариат зэрэг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж иргэдэд үйлчилж байна.

Төрийн үйлчилгээг шуурхай нээлттэй, ил тод, чирэгдэлгүй болгох, үйл ажиллагаанд хяналт тавих, иргэдийн санал бодлыг судлах, төрөөс гаргах шийдвэр боловсруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ИТХТ-ийн дэргэд “Иргэн, иргэний нийгмийн байгууллагуудын орон тооны бус зөвлөл”, Эрдэнэбулган сумын баг бүрт “Мэдээлэл түгээх сүлжээ”-г тус тус байгуулан ажиллах журам чиглэл тогтоон үйл ажиллагааг нь тогтмолжуулсан.

Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, төрийн байгууллагуудын стратеги, хэтийн төлөвлөгөө боловсруулахад иргэд, нийгмийн бүлгүүдийн санал бодлыг нээлттэй хэлэлцүүлэг, судалгаа хэлбэрээр авч тулгамдсан асуудлыг нь олж төлөвлөх, бодлого тодорхойлоход ашиглаж байна.

2009 онд Чулуут, Өлзийт, Цэнхэр сумдын эдийн засаг нийгмийн хөгжлийн төлөвлөгөө, аймгийн эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл боловсруулахад төрийн болон төрийн бус байгууллага, иргэд нийгмийн бүлгүүдийн саналыг авч тусгав.

Шийдвэр гаргах түвшинд иргэд, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ИТХТ-ийн шийдвэрээр аймгийн ИТХ-ын дэргэд “Иргэдтэй харилцах танхим” нээн ажиллуулж байна.

## **2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал**

Аймаг, сумдын Засаг даргын Тамгын Газар, Засаг даргын эрхлэх хүрээний агентлагууд болон үйлчилгээний байгууллагууд өөрийн үйл ажиллагааны чиг үүрэг, өөрийн байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээ, зөвшөөрөл эрх олгох, бүртгэл хийхэд бүрдүүлэх баримт материалын загвар, журам, заавар зэргийг мэдээллийн самбарт ил тавьж иргэд танилцах боломжоор хангасан. Хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтэд мэдээлж лавлагаа тайлбар өгч байна.

Хашаат, Өгийнуур, Хангай, Цахир, Хотонт сумдын Засаг даргын Тамгын Газрын дарга, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга, Тээвэр авто замын газрын даргын сонгон шалгаруулалтыг хэвлэл мэдээллээр зарлан явуулж, тэнцсэн иргэдийг удирдах ажилтны нөөцөд бүртгэн нэр дэвшүүлж, томилгоо хийлгүүлэв.

Сумдын Засаг даргын Тамгын Газар, хэрэгжүүлэгч агентлагуудаас Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны захиалга авч нэгтгэн Төрийн албаны зөвлөлөөр дамжуулан төвийн хэвлэл, вэб сайтаар нийтэд мэдээлж, төрийн албаны мэргэшлийн шалгалтыг 3 удаа зохион байгуулан явуулж төрийн захиргааны албан тушаалын нөөцөд 161 иргэн бүртгэгдсэнээс 46 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулав.

Аймаг, сумдын Засаг даргын Тамгын Газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагийн төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт болон үр дүнгийн гэрээнд төрийн албан хаагчийн ёс зүйг чанд сахиж ажиллахыг тусгайд нь нэг заалт болгон оруулж 2009 оны гэрээ дүгнэхдээ харгалзан тооцов.

Төрийн албаны тухай хууль, дотоод журам зөрчсөн, ажлын сахилга бат алдаж хариуцлага сулруулсан, үүрэг даалгавар биелүүлээгүй ажилтнуудтай хууль тогтоомжоор олгогдсон эрх хэмжээний хүрээнд шат шатандаа хариуцлага тооцож байна. 2009 онд аймгийн Засаг даргын захирамжаар 4, сумдын Засаг дарга нарын захирамжаар 30 гаруй, аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар 3, сумдын Засаг даргын

Тамгын Газрын даргын тушаалаар 16 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулан хариуцлага тооцсон.

### **3. Төсөв, санхүүгийн ил тод байдал**

Төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбогдуулан аймгийн Аудитын газар улсын болон орон нутгийн төсвийн 66 байгууллагын 2008 оны санхүүгийн тайланд аудит хийж төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой 17,1 сая, бүртгэл тайлантай холбоотой 320,1 сая төгрөгийн зөрчил илэрч аудитын явцад залруулагдсан.

2009 онд төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаарх мэдээлэл “Архангайн амьдрал” сонинд 4 удаа нийтлэгдсэн.

Аймгийн ИТХ-ын 2009 оны 12-р сарын 23-ны өдрийн 5-р хуралдаанаар хэлэлцсэн аймгийн Аудитын газрын тайланд орон нутгийн төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчил дутагдлыг тодорхой тусгаж нийтэд мэдээлсэн

Аймгийн ИТХ-ын тогтоолоор “Төсвийн хөрөнгийн зарцуулалт, түүний үр ашгийн байдалд шалгалт хийх ажлын хэсэг” байгуулж Өндөр-Улаан, Цэцэрлэг, Цэнхэр сумдын Засаг даргын Тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, сургууль, цэцэрлэг, хүн эмнэлэг, аймгийн Эрүүл мэндийн газар, Боловсрол соёлын газруудад шалгалт хийлгүүлэв. Аймгийн ИТХТ-ийн хуралдаанаар “Орон нутгийн төсвийн нөөцийн болон замын сан, хөрөнгө оруулалтын сангийн хуваарилалтын байдал”, Орон нутгийн болон улсын төсвийн байгууллагуудын 2008 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн”-г хэлэлцэн цаашид ажиллах ажлын чиглэл гаргаж мөрдүүлэв.

### **4. Бараа,ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендерийг зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулав.

2009 онд улсын төсвийн хөрөнгөөр 14 объектод тендер зарлан 1,9 тэрбум төгрөгийн, зээл тусламжийн хөрөнгөөр 4 объектод 149,3 сая төгрөгийн барилга угсралтын болон барилга засвар, халуун ус, худаг гаргах, тэжээлийн агуулах барих ажлууд хийгдлээ.

#### **Тав. Үйл ажиллагааны үр дагаварын үнэлгээ**

##### **1. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ**

Монгол Улсын Засгийн Газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх ялангуяа эдийн засгийн хямралтай үед эдийн засгийн хөгжилд гарсан амжилтыг тогтворжуулах бодлого баримтлан удирдлага, зохион байгуулалтын талаар авч

хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнд 2009 онд эдийн засаг ,нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдэд бодит үр дүн гарсан байна.

Монгол Улсын Засгийн Газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийн үнэлгээний дундаж оноо 3.89-5.0 болж байгаа өмнөх оныхоос нэмэгдсэн байна.

Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн өмнөх оныхоос өсч зарим нэр төрлийн өргөн хэрэглээний барааны үнэ буурсан дүнтэй байгаа нь үйлдвэрлэлтийн хэмжээ нэмэгдэж, ажлын байрны тоо өссөн байна.

Орон нутгийн төсвийн орлого, зарлагын тэнцвэрт харьцаа хангагдаж төсвийн зардалд өөрийн орлогын эзлэх хувь өсч орон нутгийн төсвийн урсгал өр авлага өмнөх оныхоос буурсан байгаа нь төрийн байгууллагуудын үйл ажиллагаа хэвийн явагдах таатай орчин бүрдүүлж ажиллалаа.

Малын тоо толгой өнгөрсөн оныхоос малын төрөл бүр дээр өсч нийт дүнгээрээ 239.0 мянган толгойгоор өссөн боловч эрчимжүүлсэн мал аж ахуй эрхэлдэг фермер нөхөрлөлийн бүлгийн тоо нэмэгдээгүй байна.

Нийгмийн үзүүлэлтүүдийн хувьд боловсрол, соёл, гэмт хэргийн илрүүлэлт зэрэг үзүүлэлтүүд өссөн дүнтэй гарч байгаа боловч эрүүл мэнд, ядуурал, шилжилт хөдөлгөөний үзүүлэлт хангалтгүй дүнтэй гарсан байна.

## **2. Хэрэглэгчийн үнэлгээ**

Засгийн Газрын тогтоол болон аймгийн Засаг даргын баталсан 2007 оны 01 тоот захирамжийн дагуу төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийхдээ иргэд, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээг харгалзан үзэж байна. Төрийн албаны чанар, үйлчилгээний хүртээмж иргэдийн санаа сэтгэлд хэр нийцэж буйг үнэлэх санал асуулгын хуудас болосруулж 15 сумын 320 иргэнээс үнэлгээ авах ажлыг ЗДТГ-ын ХШҮ-ний тасгаас зохион байгуулж дүгнэлээ.Иргэдээс тухайн суманд Засгийн газрын болон Засаг даргын хөтөлбөр хэрхэн хэрэгжиж байгааг, сумын ЗДТГ, багийн засаг дарга нарын ажилд ямар үнэлгээ өгч буйг, захиргааны болон эмнэлэг, боловсролын байгууллагын үйлчилгээ хэр чанартай, шуурхай , хүртээмжтэй буйг 1-5 онооны /5-маш сайн, 4-сайн, 3-хангалттай, 2-хангалтгүй, 1-маш муу/ үнэлгээгээр авсан.Дүнг нэгтгэж үзэхэд үнэлгээ өгсөн иргэдийн 62,4%- хангалттай, 15,5%-сайн, 12,0%-маш сайн, 10,1% хангалтгүй гэж дүгнэжээ.

Мөн аймгийн ИТХ-ын ажлын алба, ТББ-ын орон тооны бус зөвлөл хамтран аймгийн төвд 172 хүнээс төрийн байгууллагын ажил үйлчилгээний чанар, хүртээмж, цаашид авах арга хэмжээний талаар санал асуулгаар судалгаа хийсэн.Уг санал асуулгад хамрагдсан 101 хүн нь ямар нэгэн асуудлаар төрийн байгууллагад хандаж үйлчилгээ авч,санал хүсэлт гаргасан байна. Үүний 44 хүн буюу 45% нь тавьсан асуудал, санал хүсэлттэй хариулт аваагүй гэж дурьджээ. Орон нутгийн төр захиргааны байгууллагад ажлын цаг ашиглалт муу,ажлаа мэдэхгүй чирэгдүүлэх,

шийдвэрлэх чадваргүй ажилтан олон зэрэг дутагдал бйадгийг иргэд тодорхойлсон байна.

Цаашид хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээг хөндлөнгийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр төлөвлөж байна. Гэвч судалгаа шинжилгээний туршлагагүй, боловсон хүчин, материаллаг нөөцгүй, өөрсдийн санаачлагагүй байдал нь ИНБ-даар гүйцэтгүүлэхэд хүндэрэл учруулдаг.

Аймгийн ЗДТГ-аас сумдын 2009 оны ажилд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөхөд үндсэн 6 үндсэн үзүүлэлтийн нийлбэрийн дундаж үнэлгээгээр 10 сум хангалттай Булган, Өлзийт, Чулуут, Өгийнуур, Хангай зэрэг 9 сум дутагдалтай гэж дүгнэгдэв.

Хэлтэс агентлагуудаас Боловсрол соёлын газар, Биеийн тамир спортын газар “маш сайн” Татварын хэлтэс, Статистикийн хэлтэс, Цагдаагийн хэлтэс, ШШГА, ЭМГ, НДХ, ХХҮХ, МХГ зэрэг 14 байгууллага “сайн”, ХХААЖДҮГазар, УЦУОШТ, Музей” хангалттай” үнэлгээ авсан

Нутгийн захиргааны байгууллагуудын 2009 оны ажилд хийсэн хяналт шинжилгээгээр сумдын ажил “хангалттай”, агентлаг байгууллагын ажил “сайн” гэсэн дүнтэй үнэлэгдлээ.

Энэ онд сум, байгууллагын ажилд хяналт шинжилгээ хийдэг журмаа шинэчлэн боловсруулж мөрдөхөөр төлөвлөж байгаа бөгөөд Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж, төрийн ажлын талаар иргэдийн үнэлгээ, санаа бодлыг судлан дүгнэлт өгөх үйлчилгээг гүйцэтгэхийг дэмжих бодлого барьж байна.

Аймгийн Засаг дарга, Тамгын Газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ 2.66, бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ 4.17, байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ 4.49, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ 4.35, үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ 3.8 оноотой үнэлэгдэж, ерөнхий үнэлгээ 3.89 оноотой дүгнэгдлээ.

ТАЙЛАН БИЧСЭН:  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Л.ЧАДРААБАЛ

